

Зохион найруулсан эхээс
баримтын, учир зүйн холбох үгийг
буруу хэрэглэсэн алдааг таньж,
найруулгыг сайжруулах

VIII анги

Хичээлийн зорилго

- ~~Найруулгын алдааны төрлүүдийг мэдэж авах~~
- Баримтын болон учир зүйн алдаа гаргасан өгүүлбэр болон алдаагүй өгүүлбэрийг харьцуулан унших
- Баримтын болон учир зүйн алдааг ялган таних
- Баримтын болон учирзүйн алдаатай нийлмэл өгүүлбэр болон цогцолбор бичил эх унших
- Эхээс найруулгын алдааг олж, тайлбарлах

Найруулга зүйн шаардлага

Ерөнхий шаардлага

- Ойлгомжтой
- Үг сонголт сайтай
оновчтой
- Товч хураангуй
- Гоо зүй хийгээд
учир зүйд нийцсэн

Тусгай шаардлага

- Сонирхолтой
- Яруу сайхан
- Нэгэн загвартай
- Зохиогчийн
онцлог, арга барил
туссан байх

Найруулгын алдаа яагаад үүсдэг вэ?




Бичгийн хэлний хэм хэмжээ, найруулга зүйн шаардлагыг зөрчсөнөөс найруулгын алдаа үүсдэг. Алдаа нь бичигчээс их шалтгаална.

Найруулгын алдааг ангилах нь



Баримтын алдаа :

Тухайн юм үзэгдэл, баримтын талаар мэдэхгүй буюу тойм төдий төсөөлөлтэй байснаас, гүйцэд лавлаагүй зэргээс болж үүсдэг алдаа.



Цэг
Таслал
Үг , үсэг
Тоо баримт

ЖИШЭЭ НЬ:

Бээжингийн олимпийн галт бамбарыг 14663 хүн хамгаалан дагана. Үүнээс: Аж үйлдвэр бизнесийн 4471, БСШУ-ны 2231, тамирчид 669, тариачин 496, гадаадын 391, сайн дурын 3796

12054

- Нийт есөн алт нэг мөнгө, хоёр хүрэл, нийт 12 медаль зүүж, багийн дүнгээр тэргүүн байр эзэлсэн.

(Өдрийн сонин, 2007.01.12 өдөр)

Энэ өгүүлбэрт таслал орхисон учраас баримтын алдаа болсон.

Учирзүйн алдаа

Сэтгэхүйн хууль, учир шалтгааны хэм хэмжээг зөрчсөний улмаас үүссэн алдааг учирзүйн алдаа гэдэг. Уг алдаа нь уншигчдад эргэлзээ төрүүлж, унших явцыг сарниулдаг сөрөг талтай. Өөрөөр хэлбэл өгүүлэгч этгээд өгүүлж бичиж байгаа зүйлийнхээ холбоо дэс дарааг алдсанаас үүснэ.

Жишээ нь:

- Нийслэлээс хуруу хүрэм зайд орших Батсүмбэр суманд очиход маш хол байлаа. \ сониноос\
- Мал дээр өссөн хүүхэд болохоор багадаа морь унаж сурсан юм. Ямар сайндаа морио шилгэхэд уначих вэ дээ. \ сониноос\

(Учир шалтгааны үндэслэлийг зөрчсөн алдаа гаргасан)

Хаалттай үзүүлэх тоглолт болно. Өргөнөөр ирж үзнэ үү. (Телевизийн зарлал)
“Хаалтай” гэж өргөнөөр оролцох боломжгүй зүйлийг хэлдэг.

Бүх нийтэд нээлттэй үзүүлэх тоглолт болно. Өргөнөөр ирж үзнэ үү.

Учир зүйн ямар алдаа байгааг тайлбарлаарай

- Хатсан навчис сэржигнэн унахад намрын хонгор салхи үлээнэ.

Намрын хонгор салхи үлээж, навчис сэржигнэн унана.

- Хувцсаа дасгах журмаар нимгэлэх ба биеийн тамирын дасгал, хөдөлгөөнт тоглоомыг хийхэд чөлөөтэй хөдөлж болохоор хувцас өмсөнө.
- Биеийн тамирын дасгал, хөдөлгөөнт тоглоомыг хийхэд чөлөөтэй хөдөлж болохоор хувцас өмсөнө.



Өгүүлбэрүүдийн найруулгыг хэрхэн сайжруулан бичсэнгийг ажиглая.

Эх өгүүлбэр	Зассан хувилбар
Олон тооны зөгий нэгэн үүрэнд бүл үүсгэн амьдардаг.	Олон зөгий нэг үүрэнд бүл үүсгэн амьдардаг.
Хатан зөгий зуны улиралд үүрнийхээ зургаан талт хонхорцогт өндөг гарган, нэгээс нөгөөд шилжин явж өнгөрөөнө.	Хатан зөгий үүрнийхээ зургаан талт хонхорцгийн нэгээс нөгөөд дамжин өндөглөж, зуны улирлыг өнгөрөөнө.
Зөгийн бүлийн нөгөө хэсгийг эрэгчин зөгий эзлэх ба нэг бүлийн дотор хэдэн арваад байдаг.	Зөгийн бүлийн нөгөө хэсэг болох эрэгчин зөгий нэг бүлд хэдэн арваараа байдаг.
Хатан зөгийд үр тогтоох үүргийг эрэгчин зөгий гүйцэтгэнэ	Эрэгчин зөгий хатан зөгийд үр тогтооно.
Цэцгийн шүүс зөгийн шүлстэй нийлэн, бал болон хувирна.	Цэцгийн шүүс, зөгийн шүлстэй нийлэн бал болно.


Эхийн өгүүлбэр бүрийн найруулгыг хянаж, шаардлагатай өгүүлбэрийн засаж найруулъя. Бичихдээ учир зүйн дарааллыг сайтар бодоорой.

Зөгийн бүлийн дотроос хамгийн том нь хатан зөгий. Хатан зөгий нь өндөглөдөг ганц зөгий юм. Ажилчин зөгий гэдэг нь үржлийн эрхтэн нь дутуу хөгжсөн эмэгчин зөгий юм. Ажилчин зөгийнүүд үүрээ хамгаалах, өндөг авгалдайг асрамжлах, тэжээл бэлтгэх, үүр барих үүрэг гүйцэтгэнэ. Эрэгчин зөгийнүүд биеэр хатан зөгийнөөс бэсрэг, ажилчин зөгийнөөс бадриун байхын дээр толгойныхоо дагзанд хүрсэн том нүдтэй байна. Эрэгчин зөгий тэжээл бэлтгэх, өндөг, авгалдайг асрамжлахад үл оролцоно. Ажилчин зөгий цэцгээс цэцэгт дамжин нисэх зуураа цэцгийн амттайхан шүүсийг хошуугаараа сорон цуглуулж, улаан хоолойн өргөссөн хэсэг болох ходоодондоо хуримтлуулна. Үүрнийхээ хүрэлцэн ирсэн зөгий энэхүү балыг үүрийн хонхорцгуудад шахан хийдэг.

Зөгийн бүл дотроос өнлөглөдөг, хамгийн том зөгий нь хатан зөгий юм. Харин эрэгчин зөгий нь биеэр хатан зөгийнөөс бэсрэг, ажилчин зөгийнөөс бадриун байхын дээр толгойныхоо дагзанд хүрсэн том нүдтэй. Эрэгчин зөгий тэжээл бэлтгэх, өндөг, авгалдайг асрамжлахад үл оролцоно.

Ажилчин зөгий гэдэг нь үржлийн эрхтэн нь дутуу хөгжсөн эмэгчин зөгий юм. Ажилчин зөгийнүүд үүрээ барих, хамгаалах, өндөг авгалдайг асрамжлах, тэжээл бэлтгэх үүрэг гүйцэтгэнэ. Ажилчин зөгий цэцэг дамжин нисэж, амттайхан шүүсийг сорон цуглуулан, улаан хоолойн өргөссөн хэсэг болох ходоодондоо хуримтлуулна. Үүрнийхээ хүрэлцэн ирсэн зөгий энэхүү балыг үүрийн хонхорцгуудад шахан хийдэг.

Өмнөх засаж сайжруулсан өгүүлбэрүүдийг нэгтгэн “Балт зөгий” нэртэй эх болгон найруулж бичээрэй. Учир шалтгааны холбоотой өгүүлбэрүүдийг нэгтгэн нийлмэл өгүүлбэр болгон найруулна уу. Үлгэрлэвэл:



1. Хатан зөгий нь өндөглөдөг ганц зөгий юм.

2. Хатан зөгий үүрнийхээ зургаан талт хонхорцгийн нэгээс нөгөөд дамжин өндөглөж, зуны улирлыг өнгөрөөнө.

Нийлүүлж найруулсан хувилбар:

Хатан зөгий нь өндөглөдөг ганц зөгий тул үүрнийхээ зургаан талт хонхорцгийн нэгээс нөгөөд дамжин өндөглөж, зуны улирлыг өнгөрөөнө.

Анхаарал тавьсанд баярлалаа.